

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР

2020.10.29-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ШУУРХАЙ ХУРЛААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

2020.11.09

№	Товч агуулга	Биелэлт
1	НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны шалгаруулалтанд оролцох материалыг товлосон хугацаанд ирүүлэх	2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр алба, тасаг, хэсгүүдэд НЗДТГ-ын 2019 оны А/888 дугаар захирамжлалаар батлагдсан журмын дагуу шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудаа хамт олны хурлаар хэлэлцэн саналыг хүний нөөцийн албанд ирүүлэхийг epg.ulaanbaatar.mn чатаар хүргэсэн. 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Удирдлагын багийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны шалгаруулалтанд оролцох ажилтнуудын материалыг товлосон хугацаанд хүргэнэ.
2	2020 оны жилийн эцсээр өр авлагагүй гарахад анхаарч ажиллах	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас хэмнэсэн зардлыг бүлэг хоорондын шилжүүлгээр төсөв хүрэлцэхгүй байгаа зардлууд руу шилжүүлэн өрийн хэмжээг бууруулан ажиллаж байна. Өр шийдвэрлүүлэх тухай НЭМГ болон ЭМЯ-руу албан бичиг хүргүүлсэн.
3	Эмчилгээний хоолны чанар, аюулгүй байдалд хийсэн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах	<ul style="list-style-type: none"> • Энгийн хоолонд нэмэлт амлагч хийхийг зогсоосон бөгөөд эмчилгээний хоолонд хоолны давсны хэмжээг 2018 оны 01 сарын 23-ны өдрийн ЭМС-ын А/16 тушаалын дагуу 2-3 гр заасан хэмжээг хийж олгож байна. • Тасаг нэгжид эрүүл хооллолтын булан хийх мэдээллийн эх бэлтгэл дээр ажиллаж байгаа бөгөөд байгууллагын вэб хуудсанд эрүүл хооллолт, жирэмсэн үеийн хооллолтын зөвлөмж хичээлийг байршуулсан. • 2020.10.06-нд нийт эмч нарт “Эмчилгээний хоолны ач холбогдол, ангилал, удирдамж, тушаал, стандарт нэршлийн талаар сургалт явуулсан. Хамрагдсан эмчийн тоо - 74 • 2010.10.08-нд 2018 оны 01 сарын 23-ны өдрийн ЭМС-ын Дугаар А/16 тушаалын дагуу эрхтэн тогтолцооны өвчний үеийн хоол эмчилгээ болох Ходоодны өвчний үеийн хоол <ul style="list-style-type: none"> - Элэг, цэсний өвчний үеийн хоол - Нойр булчирхайн өвчний үеийн хоол - Чихрийн шижний өвчний үеийн хоол

		<ul style="list-style-type: none"> - Бөөрний өвчний үеийн хоол - Зүрх судасны өвчний үеийн хоол - Энгийн хоол зэрэг өвчний нэршлээр тус бүр эмчилгээний хоолтой үйлчлүүлэгчдэд тухайн өвчний үеийн хоолны тайлбартай нэрийн хуудсыг ашиглаж байна. • 2020.10.23нд резидент /32/ эмч нарт эмчилгээний хоолны талаар сургалт явуулав • 2020.10.30нд Эх барих тасгийн ЖЭЭХ-т 32 жирэмсэн ээжүүдэд Эрүүл хооллолт, жирэмсэн үеийн хооллолт сэдвээр сургалт зохион байгуулсан. • 2020.11.02нд Амбулаторийн тасаг хэсэгт 13 ээжид Эрүүл хооллолт, жирэмсэн үеийн хооллолт, анхаарах зүйлсийн талаар сургалт хийсэн. • 2020.11.04-ний өдөр Шим тэжээл судлалын төвөөс зөвлөх үйлчилгээ авсан. Зөвлөмжийн хариуг хүлээж байна.
4	ТТТӨ болон коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, дадлага сургалтыг тогтмол явуулах	Томуу томуу төст өвчин болон коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор амьсгалын замын халдварт өвчний шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчид зориулсан амны хаалтыг хүлээн авах хэсэгт бэлэн байлгаж байна. Амны хаалт зүүх, гараа угаах зэрэг санамж анхааруулгыг хүний нүдэнд ил харагдах газруудад байрлуулсан. Коронавируст халдварын үед ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дарааллаар сургалтыг хуваарийн дагуу хийж байна.
5	“Маскаа зүүе, Гараа угаая” аяныг байгууллага бүр дэмжин ажиллах, эмнэлгийн орчинд амны хаалт тогтмол хэрэглэх заавар зөвлөмжийг хүргэх хөтөч ажиллуулах	Тус амаржих газар нь “Маскаа зүүцгээе, гараа угаая”- 2 аяныг хэрэгжүүлэх удирдамж боловсруулан ажиллаж байна. Аяны хүрээнд эмэгтэйчүүдийн хэсэг, амбулаторийн хэсгийн хүлээн авах болон эх барих тасгийн хүлээн авах дээр хөтөч сувилагч ажиллуулан үйлчлүүлэгчийн халуун хэмжих амны хаалтаа зүүх шаардлага тавин ажиллаж байна. Мөн бүх тасаг хэсгийн мэдээллийн самбар дээр амны хаалт зүүе, гараа угаая уриалгыг байршуулан иргэд үйлчлүүлэгч болон ажилчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан аянтай холбоотой зурагт хуудас мэдээллийг хүргэн ажиллаж байна.
6	Иргэдийг олноор нь бөөгнөрүүлж үзлэг оношилгоо хийхгүй байхад анхаарч зохицуулах,	Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах иргэд цахим бүртгэлийг дуудсан дугаарын дарааллаар үйлчилгээ авах хүртэл 1.5-2.0 метрийн зайд хүлээлгийн танхимд суулгаж байна. Цаг авсан үйлчлүүлэгчид хөтөч сувилагч биеийн температурын хэмжилт хийж гарыг халдваргүйжүүлж, маск зүүлгэн үзлэг оношлогоо хийлгэх кабинетыг чиглүүлэн нэвтрүүлж байна. Үйлчлүүлэгчийн ар гэрийнхнийг хүлээлгийн танхимд эрүүл мэндийн боловсрол олголтыг видеогоор үзүүлж болон

		зарлан мэдээлэх системийн тусламжтайгаар Ковид-19 талаарх мэдээллийг хүргэж байна.
7	ТТТӨ-ний хүрээнд хийсэн ажлын тайланг сар бүр тогтмол ирүүлэх	Томуу томуу төст өвчний шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг Жирэмсний эмгэг эмчлэх хэсгийн 226, 238 өрөөнүүдэд тусгаарлан эмчилж байна. Тус өрөөнүүдийн гадна талд амны хаалт, зөвлөмж, өрөөн дотор агаар цэвэршүүлэгчийг байрлуулсан. Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх ажлын тайланг заасан хугацаанд тогтмол явуулж байна.